

БАТЛАВ  
ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД ХОТЫН ЗАХИРАГЧ Б.ХАТАНБААТАР



БАТЛАВ  
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГА Д.АШТАНХУЯГ



**ЗУУНМОД ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН  
БАЙГУУЛАГДАЖ БУЙ “EV NEGDEL CUP -2026” 5 ДАХЬ УДААГИЙН ОЛИМПЫН  
ТАЕКВОНДОГИЙН ОЛОН ХОТЫН НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

**ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:**

- Таеквондогийн спортыг сурталчлах
- Монгол улсад олимпын таеквондогийн спортыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад таеквондогийн спортоор хичээллэх ач тусыг таниулах
- Баг тамирчдын ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

Зохион байгуулагч	1. Монголын Таеквондогийн Холбоо 2. Эв нэгдэл таеквондогийн клуб
Холбоо барих	99552654, 98071727
E-mail	idermunkhtkd@gmail.com
Facebook хуудас	Mongolian taekwondo federation, Эв нэгдэл таеквондо клуб
Бүртгэлийн систем	www.mongol-taekwondo.com

**ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:**

Өдөр	Хөтөлбөр	Байршил
4-р сарын 6-19 хүртэл	❖ Бүртгэл хаагдана.	www.mongol-taekwondo.com
4-р сарын 23 нд	❖ Тамирчдын жин үзнэ	
	❖ Тэмцээний техникийн зөвлөгөөн, сугалаа	
4-р сарын 24, 25, 26 нд	❖ Тэмцээн	Төв аймаг Зуунмод сум Биеийн тамир спортын газар

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.
- ❖ Бүртгэл хаагдсаны дараа оролцогч тамирчдын жин үзүүлэх байршил болон хугацааг олон нийтэд мэдээнэ.

## ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

### 1. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна. Тэмцээний үеэр зөвхөн тэр бүсээ бүсэлж тухайн бүсний ангилалдаа өрсөлдөнө.
- Тэмцээнд оролцогч тамирчин бүр таеквондогийн ёс, дэг журмыг чанд баримтлан, хувийн ариун цэврийг дээд зэргээр хангасан байх шаардлагатай. Үүнд: гар хөлийн хумсыг засаж, элдэв бөгж, хүзүүний зүүлт зэргийг хэрэглэхгүй байх.
- Тамирчин нь Монголын таеквондогийн цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна. Хэрэв лиценз шинээр авах эсвэл сунгуулах шаардлагатай бол тэмцээнд бүртгүүлэхээс өмнө лицензийн хураамж болох 50.000₮ (тавин мянган төгрөг) Хаан банкны 5431161905 тоот Монголын таеквондогийн холбооны дансанд шилжүүлснээр тэмцээнд оролцох эрх нээгдэнэ.
- 6, 7 настай тамирчид лиценз авахгүй, мэдүүлгийг майл хаягаар хүлээн авна. Мэдүүлэг хүлээн авах хаяг [idermunkhtkd@gmail.com](mailto:idermunkhtkd@gmail.com)
- Тамирчдын жинг олон кг-р хасахгүй байхыг нийт багш, дасгалжуулагч нарт онцгой анхааруулж байна.
- Тэмцээнд оролцох тамирчид Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөж тэмцээнд оролцох шаардлага тавигдана.



- А ангиллын тулаан KPNP цахим онооны системээр явагдах бол В, С ангиллын тамирчдын тулаан цахим бус энгийн хамгаалалт дээр явагдана.
- Бага нас, өсвөр үеийн тамирчид тулааны үеэр нүүрний хамгаалалт буюу касктай тулалдана. Залуучууд, насанд хүрэгчдийн тамирчид тулааны үеэр нүүрний хамгаалалтгүй шүдний хамгаалалттай тулалдана.
- Шүдний хамгаалалтын хувьд өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэйгээс бусад өнгөтэй шүдний хамгаалалт зүүхийг хориглоно.
- В болон С ангиллын тамирчид энгийн хамгаалалттай тулалдах ба цээж, толгой болон нүүрний хамгаалалтыг багууд өөрсдөө бэлдэж ирнэ. KPNP цахим хамгаалалтыг тэмцээн зохион байгуулагч тал хариуцах ба тамирчдын электрон оймсыг клуб хариуцан бэлдэж ирнэ.
- Нэг байгууллагаас оролцох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй.
- Шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас /костюм/ өмсөх шаардлагатай.

## 2. ОРОЛЦОГЧИЙН НАС БОЛОН АНГИЛАЛ:

### 2.1 Дараах насны ангиллаар өрсөлдөнө.

- Бага нас 6 нас жин, харгалзахгүй, ижил бүстэй тамирчид 4\*4-р өрсөлдөнө.
- Бага нас 7 нас жин харгалзахгүй, ижил бүстэй тамирчид 4\*4-р өрсөлдөнө.
- Бага нас 8-9 нас
- Бага нас 10-11 нас
- Өсвөр үе 12-14 нас
- Залуучууд 15-17 нас

### 2.2 Дараах бүсний ангиллаар өрсөлдөнө

- Бага нас 8-9, 10-11, Өсвөр үе, залуучуудын насны тамирчид ангилал тус бүрдээ А (хар бүстэй тамирчид), В (улаан, цэнхэр бүстэй тамирчид), С (шар, ногоон бүстэй тамирчид) гэсэн үндсэн гурван бүсний ангиллаар тулалдана.

## 3. ЖИНГИЙН ДАРААЛАЛ:

### Бага нас (8-9 нас) 2017-2018 онд төрсөн тамирчид

Эр		Эм	
-24 кг	24 кг хүртэлх	-23 кг	23кг хүртэлх
-26 кг	24кг жингээс 26кг жингийн хооронд	-25 кг	23кг жингээс 25кг жингийн хооронд
-28 кг	26кг жингээс 28кг жингийн хооронд	-27 кг	25кг жингээс 27кг жингийн хооронд
-30 кг	28кг жингээс 30кг жингийн хооронд	-29 кг	27кг жингээс 29кг жингийн хооронд
+30 кг	30кг жингээс дээш жинтэй тамирчид	+29 кг	29кг жингээс дээш жинтэй тамирчид

### Бага нас (10-11 нас) 2015-2016 онд төрсөн тамирчид

Эр		Эм	
-26 кг	26 кг хүртэлх	-25 кг	25кг хүртэлх
-29 кг	26кг жингээс 29кг жингийн хооронд	-28 кг	25кг жингээс 28кг жингийн хооронд
-32 кг	29кг жингээс 32кг жингийн хооронд	-31 кг	28кг жингээс 31кг жингийн хооронд
-35 кг	32кг жингээс 35кг жингийн хооронд	-34 кг	31кг жингээс 34кг жингийн хооронд
-38 кг	35кг жингээс 38кг жингийн хооронд	-37 кг	34кг жингээс 37кг жингийн хооронд
+38 кг	38кг жингээс дээш жинтэй тамирчид	+37 кг	37кг жингээс дээш жинтэй тамирчид

### Өсвөр үе (12-14 нас) 2012-2014 онд төрсөн тамирчид

Эр		Эм	
-33 кг	33 кг хүртэлх	-29 кг	29кг хүртэлх
-37 кг	33кг жингээс 37кг жингийн хооронд	-33 кг	29кг жингээс 33кг жингийн хооронд
-41 кг	37кг жингээс 41кг жингийн хооронд	-37 кг	33кг жингээс 37кг жингийн хооронд
-45 кг	41кг жингээс 45кг жингийн хооронд	-41 кг	37кг жингээс 41кг жингийн хооронд
-49 кг	45кг жингээс 49кг жингийн хооронд	-44 кг	41кг жингээс 44кг жингийн хооронд
-53 кг	49кг жингээс 53кг жингийн хооронд	-47 кг	44кг жингээс 47кг жингийн хооронд
-57 кг	53кг жингээс 57кг жингийн хооронд	-51 кг	47кг жингээс 51кг жингийн хооронд
-61 кг	57кг жингээс 61кг жингийн хооронд	-55 кг	51кг жингээс 55кг жингийн хооронд
+61 кг	61кг жингээс дээш жинтэй тамирчид	+55 кг	55кг жингээс дээш жинтэй тамирчид

Залуучууд (15-17 нас) 2009-2011 онд төрсөн тамирчид

Эр		Эм	
-45 кг	45 кг хүртэлх	-42 кг	42кг хүртэлх
-48 кг	45кг жингээс 48кг жингийн хооронд	-44 кг	42кг жингээс 44кг жингийн хооронд
-51 кг	48кг жингээс 51кг жингийн хооронд	-46 кг	44кг жингээс 46кг жингийн хооронд
-55 кг	51кг жингээс 55кг жингийн хооронд	-49 кг	46кг жингээс 49кг жингийн хооронд
-59 кг	55кг жингээс 59кг жингийн хооронд	-52 кг	49кг жингээс 52кг жингийн хооронд
-63 кг	59кг жингээс 63кг жингийн хооронд	-55 кг	52кг жингээс 55кг жингийн хооронд
-68 кг	63кг жингээс 68кг жингийн хооронд	-59 кг	55кг жингээс 59кг жингийн хооронд
-73 кг	68кг жингээс 73кг жингийн хооронд	-63 кг	59кг жингээс 63кг жингийн хооронд
+73 кг	73кг жингээс дээш жинтэй тамирчид	+63 кг	63кг жингээс дээш жинтэй тамирчид

**4. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ:**

Улаанбаатар хотын болон Төв аймгийн тамирчид 50,000 (тавин мянган төгрөг) төгрөг

Хөдөө орон нутгийн тамирчид:

- Улаанбаатар хотоос 1000 км дотогш 40,000 (дөчин мянган төгрөг) төгрөг
- Улаанбаатар хотоос 1000 км гадагш 20,000 (хорин мянган төгрөг) төгрөг

Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Г.Дүүрэнжаргал

Дансны дугаар: 5031946909

IBAN: 74000500

**5. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:**

- Дэлхийн таеквондогийн холбооны дүрмийн дагуу хасагдах системээр явуулж, 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.
- Багийн дүн:
- А, В, С, гэсэн 3 ангилал тус бүрд 1, 2, 3-р байр эзэлсэн багуудыг цом, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.
- Мөн шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчин, шүүгч, дасгалжуулагчийг тодруулан шагнаж урамшуулна.